



Ерөнхийлөгч Томас С.Монсон

# Ариун сүмийн адислалууд

*Биднийг ариун сүмд очиход сүнслэг байдлын цар хүрээ, амар амгалангийн мэдрэмж бигэн рүү ирдэг.*

**Х**айрт ах, эгч нар аа, би дэлхийн Аврагч руу бидний бодол хандсан, Христийн амилсны баярын энэ гайхамшигт өглөө та бүхэнтэй хамт байгаадаа хэчнээн их талархаж байна вэ! Би та бүхний хүн нэг бүрд хайраа илэрхийлэн мэндчилж, Тэнгэрлэг Эцэг миний хэлэх үгэнд сүнслэгээр нөлөөлөөсэй хэмээн залбирч байна.

Энэхүү чуулганаар Сүмийн ерөнхийлөгч болсны маань долоон жилийн ой тохиож байна. Эдгээр он жил бэрхшээл сорилтоор төдийгүй тоо томшгүй олон адислалаар дүүрэн, тун завгүй он жилүүд байв. Эдгээр хамгийн баяр баясгалантай хийгээд ариун нандин адислалын дунд ариун сүмийг онцгойлон адислах болон заримыг нь дахин онцгойлон адислах боломж надад тохиож байсан билээ.

Хамгийн сүүлд, өнгөрсөн оны арваннэгдүгээр сард ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, ахлагч Даллин Х.Өүкс, ахлагч Ричард Ж.Мэйнс, ахлагч Линн Г.Роббинс, ахлагч Кэнт Ф.Ричадс нарын хамт Феникс

Аризонагийн үзэсгэлэнтэй Ариун сүмийг онцгойлон адислах ховор боломж надад тохиосон юм. Онцгойлон адислах ёслолын өмнөх орой нь ариун сүмийн дүүргийн дөрвөн мянга гаруй залуу эрэгтэй, эмэгтэй оролцсон соёлын гайхамшигтай арга хэмжээ болж өнгөрөв. Дараагийн өдөр нь ариун сүмийг ариун нандин ба сүнслэг өдөөлт бүхий гурван ёслолын ажиллагаагаар онцгойлон адисалсан билээ.

Ариун сүмийн барилгын ажил нь Сүмийн өсөлт хөгжлийн нэн тодорхой үзүүлэлт юм. Бидэнд одоогоор дэлхий даяар үйл ажиллагаагаа явуулж буй 114 ариун сүм байгаагаас гадна, 5 ариун сүмд засварын ажил хийгдэж, 13 ариун сүмийн барилгын ажил явагдаж байна. Үүний зэрэгцээ, саяхан зарласан 13 ариун сүмийн барилгын ажлын өмнөх бэлтгэл ажил янз бүрийн түвшинд явагдаж байна. Энэ жил бид 2 ариун сүмийг дахин онцгойлон адислахаар мөн барьж дуусгах хуваарийн дагуу 5 шинэ ариун сүмийг онцгойлон адислахаар төлөвлөөд байна.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд, бид өмнө зарлагдсан ариун сүмүүдийг барьж дуусгахад хүчин чармайлтаа төвлөрүүлсэн бөгөөд шинээр ариун сүм барих төлөвлөгөөг түр зогсоосон байгаа билээ. Гэхдээ энэ өглөө би дараах газруудад баригдах ариун сүмүүдийг зарлахад туйлын таатай байна: Зааны Ясан Эргийн Абиджан; Гайтигийн Порт-о-Принс ба Тайландын Бангкок юм. Эдгээр газар нутагт байгаа итгэлтэй гишүүдийг болон дэлхий даяар ариун сүмүүд байдаг газруудыг ямар гайхамшигтай адислалууд хүлээж байна вэ.

Бид аль болох олон гишүүнд цаг хугацаа, эх үүсвэрээ золиослохгүйгээр ариун сүм рүү очих боломжийг олгохыг хүсдэг тул шинээр ариун сүм барих хэрэгцээг тодорхойлж мөн баригдах газрыг олох явц өрнөсөөр байна. Бид өнгөрсөн хугацаанд хийж байсныхаа адил эдгээр зүйл дээр хүрсэн шийдвэрийнхээ талаар та бүхэнд мэдэгдэж байх болно.

Намайг ариун сүмийн тухай бодох бүрд тэндээс бидний хүлээн авах олон тооны адислалын тухай бодол санаанд минь орж ирдэг юм. Бид ариун сүмийн хаалгаар орох үедээ дэлхийн анхаарлыг сарниулагч зүйлс, төөрөгдлийг ардаа үлдээдэг билээ. Энэхүү ариун нандин газар бид үзэсгэлэн гоо, эмх цэгцийг олж хардаг. Тэнд бид бодгальдаа амар амгаланг авч, амьдралынхаа санаа сэтгэлийн зовиураас түр зуур амсхийдэг билээ.

Биднийг ариун сүмд очиход хүмүүний зүрх сэтгэлд төрж болох аливаа мэдрэмжээс хавьгүй хол

давсан сүнслэг байдлын цар хүрээ, амар амгалангийн мэдрэмж бидэн рүү ирдэг. Бид “Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. . . . Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай”<sup>1</sup> хэмээн Аврагчийн хэлсэн үгийн үнэн утга учрыг ухааран ойлгох болно.

Ийм амар амгалан нь зовсон, уй гашуудалдаа дарагдсан, төөрсөн, тусламж эрсэн ямар ч зүрх сэтгэлийг дүүргэх юм.

Би саяхан тусламж эрэлхийлэн, ариун сүмд очсон нэгэн залуугийн тухай мэдэж авсан юм. Тэрээр хэдэн сарын өмнө Өмнөд Америкт үйлчлэх номлолын дуудлагаа хүлээн авсан байв. Гэтэл түүний виз удаан хугацаагаар хойшлогдсон учир тэр АНУ-д үйлчлэх өөр дуудлага хүлээн авчээ. Тэрээр анх дуудагдсан газраа үйлчилж чадагчгүйдээ урам нь хугарсан ч шинээр дуудагдсан газраа өөрийнхөө чадлынхаа хэрээр үйлчлэх шийдвэр төгс, шаргуу ажиллаж эхэллээ. Гэсэн ч тэрээр сайн мэдээг хуваалцахаасаа илүү цагийг зугаатай өнгөрүүлэх дуртай номлогчидтой учирсан таагүй сэтгэгдлээсээ болж сэтгэлээр унасан байна.

Хэдэн сарын дараа тэр залуу маш хүндээр өвдөж, тал бие нь саажсан учраас номлолоосоо эрүүл мэндийн шалтгаанаар гэртээ эргэн иржээ.

Хэдэн сарын дараа тэр залуу бүрэн эдгэрч, түүний саажилт ул мөргүй алга болов. Тэрээр өдөр бүр дахин номлолд үйлчлэхийн төлөө залбирч байсны адислал ирж, түүнийг номлолд дахин үйлчлэх боломжтой гэсэн хариу иржээ. Гагцхүү сэтгэл дундуур байлгах цорын ганц зүйл нь тэрээр зарим номлогчийн биеэ авч явах байдал, хандлага нь байх ёстой жишгээс доогуур байсан гэж бодож байсан хуучин номлолдоо буцаж очих явдал байв.

Тэрээр ариун сүмд номлогчийн хувьд цаашид бүх зүйл сайн сайхан байх болно гэсэн сэтгэлийн тайтгарал, баталгааг эрэлхийлэхээр

иржээ. Залуугийн эцэг эх ч мөн адил ариун сүмд ирснээрээ тэдний хүү өөрт хэрэгтэй тусламжаа хүлээн аваасай хэмээн залбирсан байна.

Залуу ёслолын ажиллагааны дараа селестиел өрөөнд орж ирэн, сандал дээр суунгуутаа Тэнгэрлэг Эцэгээсээ удирдамж гуйн залбирч эхлэв.

Селестиел өрөөнд түүний дараахан орж ирсэн хүн бол Лэндон хэмээх өөр нэгэн залуу байлаа. Лэндонг өрөөнд орж ирэнгүүт түүний харц сандал дээр сууж, нүдээ анин, яах аргагүй залбирч байсан нэгэн залуу дээр тусав. Түүнд тэр залуутай ярих хэрэгтэй гэсэн тод томруун мэдрэмж орж ирэв. Тэр залуугийн залбирлыг тасалдуулахаасаа тээнэгэлзэн, тэрээр хүлээхээр шийдэв. Хэдэн минут өнгөрч, нөгөө залуу залбирсан хэвээр байсан ч Лэндон тэрхүү сүнслэг өдөөлтийг хойшлуулж болохгүй гэдгийг мэдэж байлаа. Тэр залууд дөхөж очин, мөрөнд нь зөөлөн хүрэв. Залуу нүдээ нээж, түүнд саад болсонд гайхаж орхив. Лэндон “Би яагаад гэдгийг нь мэдэхгүй ч надад тантай ярих хэрэгтэй гэсэн мэдрэмж төрсөн юм аа” гэж түүнд хэлэв.

Тэднийг ярилцаж эхлэхэд тэр залуу зүрх сэтгэлээ Лэндонд уудлан ярьж, нөхцөл байдлаа тайлбарлан, номлолтой нь холбоотой ямар нэгэн тайтгарал болон урам зориг хүлээн авахыг хүсэж байгаагаа хэлжээ. Жилийн өмнө л номлолоо амжилттай дуусган эргэж ирсэн Лэндон номлолынхоо туршлага, тулгарсан саад бэрхшээл, асуудлууд, Их Эзэнд хандан тусламж гуйж байсан арга зам болон хүлээн авсан адислалуудын тухай ярьжээ. Түүний хэлсэн үгс тайтгаруулсан, сэтгэлийн дэм болсон үгс байсан бөгөөд түүний номлолын урам зориг түүнд халдварлаад эцэст нь залуугийн айдас замхран алга болоход, амар амгалан болон өөрийнх нь залбирлын хариу ирсэн болохыг ухаарч, гүнээ талархах мэдрэмж түүнд төрөв.

Хоёр залуу хамтдаа залбирсны дараа, Лэндон өөрт ирсэн сүнслэг

өдөөлтийг сонссондоо тун баяртай ариун сүмээс гарахад бэлдэв. Түүнийг явах гэж байтал нөгөө залуу “Та номлолоо хаана хийсэн бэ?” гэж Лэндонгоос асуув. Тэр хүртэл тэдний хэн нь ч нөгөөдөө үйлчилсэн номлолынхоо нэрийг дурдаагүй байж. Лэндонг номлол хийсэн газрынхаа нэрийг хэлтэл залуугийн нүд нулимсаар дүүрээд ирэв. Лэндон тэр залуугийн номлол хийх гэж байгаа яг тэр газар үйлчилсэн байжээ!

Лэндон саяхан надад бичсэн захидалдаа “Би Тэнгэрлэг Эцэг намайг адисална гэдэгт итгэлтэй байсан ч Тэр миний номлолд үйлчилсэн хэн нэгнийг надад туслуулахаар илгээнэ гэдгийг хэзээ ч төсөөлж байгаагүй. Би одоо бүх зүйл сайхан байх болно гэдгийг мэдэж байна”<sup>2</sup> гэсэн тэр залуугийн салахынхаа өмнө хэлсэн үгийг хуваалцсан юм. Чин сэтгэлийн, даруухан залбирлыг сонсож, хариулсан нь энэ байжээ.

Ах, эгч нар аа, бид амьдралдаа уруу таталтуудтай учрах болно; бид сорилт бэрхшээлүүдтэй тулгарах болно. Бид ариун сүмд очихдоо тэнд хийсэн гэрээгээ санаж байвал тэдгээр уруу таталтыг даван гарах, сорилт бэрхшээлээ тэсэж гарах илүү сайн чадвартай байх болно. Ариун сүмд бид амар амгалан олж чадах билээ.

Ариун сүмийн адислалуудыг үнэлж баршгүй юм. Миний амьдралдаа өдөр бүр талархаж байдаг нэгэн адислалыг би хайрт эхнэр Франсистайгаа хамт ариун сүмд тахилын ширээний дэргэд өвдөг сөгдөн, биднийг мөнхөд холбосон гэрээнүүдийг хийж байхдаа хүлээн авсан юм. Миний хувьд бид хоёр дахин хамт байна гэсэн мэдлэгээс хүлээн авсан амар амгалан, тайтгарлаас илүү үнэ цэнэтэй адислал үгүй билээ.

Тэнгэрлэг Эцэг маань биднийг ариун сүмд шүтэн бишрэх сүнстэй, Түүний тушаалуудад дуулгавартай, бидний Эзэн, Аврагч Есүс Христийн мөрөөр алхахдаа хянамгай байхаар адислах болтугай. Би Түүнийг

бидний Гэтэлгэгч хэмээн гэрчилж байна. Тэрээр Бурханы Хүү билээ. Тэрээр амилсныхаа өглөө булнаас урагш гарч ирэн, Өөрийн хамтаар Бурханы бүх хүүхдэд мөнх амьдралын бэлгийг авчирсан. Үзэсгэлэн

төгөлдөр энэ өдөр бид тэрхүү чухал үйл явдлыг тэмдэглэж байхдаа Түүний бидэнд өгсөн агуу, гайхамшигтай бэлгийн төлөө талархлынхаа залбирлыг өргөх болтугай. Ийнхүү байх болтугай хэмээн би

Түүний ариун нэрээр даруухнаар залбирч байна, амен.

#### ЭШЛЭЛҮД

1. Иохан 14:27.
2. Correspondence in the possession of Thomas S. Monson.

## Бидэнд зориулсан сургаал

**2015** оны 5-р сараас 2015 оны 10-р сар хүртэл, Мелкизедек санваартнууд болон Халамжийн нийгэмлэгийн дөрөв дэх ням гаргийн хичээлийг 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс нэг болон түүнээс олныг сонгон бэлтгэж заана. 10-р сард, 2015 оны 4-р сар эсвэл 2015 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс сонгож болно. Гадас, дүүргийн ерөнхийлөгчид Ерөнхий чуулган дээр хэлсэн үгийг сонгож эсвэл энэ үүргийг бишоп, салбарын ерөнхийлөгчдөд даалгаж болно.

Эдгээр хэлсэн үгийг [conference.lds.org](http://conference.lds.org) хаяг руу орж, олон хэлээр унших боломжтой.



**Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф**

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

## Ач ивээлийн бэлэг

*Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй хүмүүс Бурханы ач ивээлээс өнөөдөр төдийгүй, үеийн үед хүртэх боломжтой.*

**Б**ид Христийн амилсны баярын ням гарагт дэлхийн түүхэн дэх хамгийн удаан хүсэн хүлээсэн агуу үйл явдлыг тэмдэглэдэг билээ.

Энэ бол бүхнийг өөрчилсөн өдөр.

Энэ өдөр миний амьдрал өөрчлөгдсөн юм.

Та нарын амьдрал ч мөн адил өөрчлөгдсөн.

Мөн Бурханы бүх хүүхдийн хувь тавилан өөрчлөгдсөн билээ.

Тэрхүү адислагдсан онцгой өдөр бидний нүглийн болон үхлийн ачааг хүн төрөлхтний Аврагч өөр дээрээ хүлээн авч, биднийг эрх чөлөөтэй болгосон юм.

Бидний хайрт Гэтэлгэгчийн золиослолын үр дүнд үхэлд хатгуур мөн булшинд ялалт гэж үгүй болж,<sup>1</sup> Сатан бидний дээр хүч чадлаа алдаж, бид “Есүс Христийн үхэгсдээс амилсан *амилалтаар* . . . амьд найдвар уруу”<sup>2</sup> дахин төрсөн.

Бид “эдгээр үгсээр бие биенээ тайвшруулж”<sup>3</sup> чадна хэмээн төлөөлөгч Паулын хэлсэн нь үнэхээр зөв байжээ.

### **Бурханы ач ивээл**

Бид Аврагчийн Цагаатгалын тухай үргэлж ярьдаг бөгөөд

энэ нь ч зөв зүйтэй юм.

Иаковын хэлсэнчлэн, “Яагаад Христийн цагаатгалыг ярихгүй мөн Түүний төгс мэдлэгт хүрэхгүй байх билээ?”<sup>4</sup> Гэхдээ бид олдсон боломж бүрдээ “Христийн тухай ярьж, . . . Христэд баясч, . . . Христийн талаар номлож, . . . [мөн] Христийн тухай бошиглож”<sup>5</sup> байхдаа Бурханы Хүүгийн мөнхийн золиослолыг бишрэн шүтэж, гүн талархах сэтгэлээ хэзээ ч алдах учиргүй.

Аврагчийн Цагаатгал нь бидний хичээл дээр болон хэлэх үгэнд мөн зүрх сэтгэлд энгийн нэгэн улиг болсон зүйл болон хувирах ёсгүй. Энэ нь Есүс Христийн “өөрийнх нь нэрэнд итгэгч хүн бүхний авралын төлөө” хийсэн “агуу их болоод эцсийн золиослол”<sup>6</sup> байсан учраас ариун бөгөөд нандин зүйл юм.

Төгс биш бөгөөд цэвэр ариун бус, алдаа гаргахдаа хурдан мөн талархаж мэддэггүй биднийг аврахаар Бурханы Хүү доош ирсэн гэдгийг бодохоор би үнэхээр гайхширдаг. Би өөрийн мөхөс оюун ухаанаар Аврагчийн Цагаатгалыг ойлгохыг хичээсэн бөгөөд Бурхан бидэнд гүн гүнзгий, хязгааргүй, төгс

хайртай гэдэг нь үүний цорын ганц тайлбар болохыг олж мэдсэн юм. Би “Христийн хайрын . . . өргөн, урт, өндөр хийгээд гүн” нь ямар болохыг таамаглаж ч чадахгүй.<sup>7</sup>

Тэрхүү хайрын тод илрэл нь судрууд дээр *Бурханы ач ивээл* хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Энэ нь биднийг сул дорой, хязгаарлагдмал байдлаас “үнэнд алдаршиж мөн бүх зүйлийг мэдэх хүртлээ үнэн ба гэрлийн” өргөмжлөгдсөн байдал руу ороход өгөгдөх тэнгэрлэг тусламж мөн хүч чадлын бэлэг юм.<sup>8</sup>

Бурханы ач ивээл гэдэг нь үнэхээр гайхамшигтай зүйл юм. Гэхдээ ихэнхдээ бид үүнийг бүрэн дүүрэн ойлгодоггүй.<sup>9</sup> Хэдий тийм ч, Бурханы мөнхийн хаант улсдаа бидэнд зориулан бэлдсэн зүйлсийг бид өвлөн авахыг хүсэж байгаа л бол Түүний ач ивээлийн талаар мэдэж байх ёстой.

Тиймээс би ач ивээлийн талаар ярих гэж байна. Ялангуяа, нэгдүгээрт, ач ивээл хэрхэн *тэнгэрийн үүд хаалгыг нээдэг*, хоёрдугаарт, энэ нь хэрхэн *тэнгэрийн цонхыг нээдэг* талаар ярья.

### **Нэгдүгээрт: Ач ивээл тэнгэрийн үүд хаалгыг нээдэг**

Бид бүгд “нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй”<sup>10</sup> бөгөөд “өчүүхэн ч цэвэр бус зүйл Бурханы хаант улсад орж чадахгүй”<sup>11</sup> учраас бидний хүн нэг бүр Түүний оршихуйд буцаж очихуйц зохистой биш юм.

Бид Бурханд бүх бодгалиараа үйлчилсэн ч энэ нь хангалтгүй бөгөөд “ашиггүй зарц нар”<sup>12</sup> хэвээр байх болно. Бид өөрсдийн хүч чадлаар тэнгэрт очиж чадахгүй. Учир нь бидний хооронд шударга ёсны

шаардлага байдаг ба бид үүнийг зөвхөн өөрийн хүчээр хийх боломжгүй юм.

Гэхдээ бидэнд найдвар бий.

Бурханы ач ивээл бидний агуу бөгөөд үүрдийн найдвар.

Есүс Христийн золиослолоор дамжуулан өршөөлийн төлөвлөгөө нь шударга ёсны шаардлагыг хангаж,<sup>13</sup> “хүмүүнд, тэд наманчлалд итгэлтэй байх тэр замыг [авчрах]” юм.<sup>14</sup>

Бидний нүглүүд час улаан байсан ч цас мэт цав цагаан болох боломжтой.<sup>15</sup> Бидний хайрт Аврагч “Өөрийгөө бүгдийн төлөө золиос болгон өгсөн”<sup>16</sup> учраас Түүний мөнхийн хаант улсад орох үүд хаалгыг бидэнд нээж өгсөн билээ.<sup>17</sup>

Хаалга нээгдсэн!

Гэхдээ Бурханы ач ивээл нь биднийг ердөө л өмнө байсантай минь адил гэм нүгэлгүй байдал руу аваачдаггүй. Хэрэв аврал нь зөвхөн бидний алдаа, гэм нүглүүдийг л цайруулдаг юм бол энэ нь хэдий гайхалтай ч гэсэн Эцэгийн бидэнд зориулсан агуу төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хангалтгүй юм. Түүний зорилго бол үүнээс ч илүү чухал зүйл болох Өөрийн охид, хөвгүүдийг Өөртэйгөө адил болгохсон гэсэн хүсэл байдаг.

Бурханы ач ивээлийн бэлгийн ачаар бидний шавь байх зам хойш бус, харин урагш хөтөлнө.

Энэ нь биднийг төсөөлөхийн аргагүй агуу өндөрлөгт аваачих юм! Энэ нь биднийг хайртай хүмүүсээрээ хүрээлүүлэн, “түүний бүрэн дүүрэн байдал болон алдар суу”-г хүлээн авах газарт буюу Тэнгэрлэг Эцэгийн селестиел хаант улс руу хөтөлнө.<sup>18</sup> Бүх зүйл биднийх бөгөөд бид өөрсдөө Христийнх билээ.<sup>19</sup> Эцэгт буй бүхэн бидэнд өгөгдөнө.<sup>20</sup>

Энэхүү алдар сууг өвлөн авах үүд хаалга бидэнд нээгдэхээс гадна, бид өөрсдөө тэрхүү хаалгаар зүрх сэтгэлээрээ орох буюу сударт “дахин төрөх ёстойд бүү гайх; тиймээ, Бурханаар төрж, эгэл [манай дэлхийн] хийгээд унасан байдлаасаа зөв шударга байдалд орж өөрчлөгдөн,

Бурханаар гэтэлгэгдэн, түүний хөвгүүд мөн охид болдог”<sup>21</sup> хэмээн тэмдэглэгдсэн байдаг шиг гүн гүнзгий өөрчлөгдөх хүсэлтэйгээр орох ёстой юм.

**Хоёрдугаарт: Ач ивээл нь тэнгэрийн цонхыг нээгээ**

Бурханы ач ивээлийн өөр нэг хэсэг бол дан ганц өөрсдийн хүчээр хэзээ ч хийж чадахгүй зүйлсийг хийж гүйцэтгэхэд минь туслах Бурханы хүч чадлын адислалыг бидэн дээр юүлэх цонхыг нээх явдал юм. Бурханы энэхүү гайхамшигт ач ивээлээр Түүний хүүхдүүд хууран мэхлэгчийн аливаа ов мэхийг даван туулж, гэм нүглийг ялан дийлж, “Христэд төгөлдөржиж”<sup>22</sup> чадна.

Хэдийгээр бидэнд сул талууд байдаг ч бид тэдгээрийг даван туулж чадна. Хэрэв бид өөрсдийгөө даруусган, итгэлтэй байж чадвал Бурханы ач ивээлээр сул дорой талууд маань үнэхээр хүчирхэгжих юм.<sup>23</sup>

Амьдралын маань туршид Бурханы ач ивээл бидний чадварыг өсгөж, амьдралыг маань баяжуулах материаллаг ба сүнслэг бэлгүүдийг өгдөг. Түүний ач ивээл биднийг цэвэршүүлдэг. Түүний ач ивээл биднийг хамгийн сайнаараа байхад тусалдаг.

**Шаардлагыг хэн хангах вэ?**

Бид Библиэс Христийн Симон хэмээх фарисай хүний гэрт айлчилсан тухай түүхийг уншдаг.

Гаднаас нь харахад Симон сайн, зөв шударга хүн байв. Тэрээр шашныхаа өмнө хүлээсэн үүргээ үргэлж биелүүлдэг байлаа. Тэр тушаалыг даган, аравны нэгээ төлж, ариун өдрийг ариунаар нь сахьж, өдөр бүр залбиран, синагог руугаа явдаг нэгэн байв.

Харин Христийг Симонтой хамт байх үед нэгэн эмэгтэй ирж, Аврагчийн хөлийг нулимсаараа угааж, үнэтэй тосоор тосолсон байна.

Симон уг эмэгтэйг нүгэлтэй нэгэн байсныг мэдэж байсан учраас сүсэг бишрэлийнх нь энэхүү илрэлийг

таашаагаагүй аж. Хэрэв Есүс үүнийг мэдээгүй бол Тэр бошиглогч биш байх байсан эсвэл тэр эмэгтэйг өөртөө хүргүүлэхгүй байсан хэмээн Симон бодож байлаа.

Түүний бодлыг мэдсэн Есүс Симонд хандаж “Нэгэн мөнгө зээлдүүлэгчид хоёр хүн өртэй байжээ. Нэг нь таван зуу, нөгөө нь тавин денарын өртэй байв.

Тэд [хоёулаа] төлөх чадваргүй тул өнөөх хүн тэднийг хоёуланг өрнөөс хэлтрүүлжээ. Тэгвэл тэдний хэн нь түүнийг илүү хайрлах бол?” хэмээн асуув.

Симон илүү өгөөмрөөр хэлтрүүлэгдсэн нь гэж хариулав.

Үүний дараа Есүс “Чи энэ эмэгтэйг харж байна уу? . . . Түүний олон нүгэл уучлагдсан. *Учир нь тэр ихэд хайрласан.* Харин багхан шигээр уучлагдсан нэг нь бага хайрладаг”<sup>24</sup> хэмээх гүн гүнзгий утга бүхий сургаалыг заасан байдаг.

Бид энэ хоёр хүний алинтай нь илүү адил вэ?

Бид Симонтой адил уу? Бид өөрсдийн зөв шударга гэдэгтээ итгэлтэй, сайн үйлсдээ итгэл дүүрэн, сэтгэл амар байж чаддаг уу? Бид бидний жишигт хүрэхгүй хэн нэгэнтэй бага зэрэг тэвчээргүй хандаад байгаа юм биш биз? Бид аливаа зүйлийг бодож тунгаагүйгээр хурал, цуглаандаа сууж, Сайн мэдээний сургаалын ангийг эвшээлгэн өнгөрүүлж, ариун ёслолын үеэр гар утсаараа оролдож суудаг автомат удирдлагын төлөвт орчихсон явж байна уу?

Эсвэл бид гэм нүглээсээ болж хэзээ ч өршөөгдөхгүй хэмээн бодож байсан энэ эмэгтэйтэй адил уу?

Бид *илүү их хайрлаж чаддаг уу?*

Бид Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө хүлээсэн үүргээ ухамсарлан, Бурханы ач ивээлийг хүртэхийн тулд сэтгэл зүрхнийхээ угаас гуйн залбирдаг уу?

Бид өвдөг сөгдөн залбирахдаа, өөрсдийн зөв шударга байдлын тухай магтаалаа давтан уншдаг уу эсвэл өөрийн бурууг хүлээн зөвшөөрч, Бурханы өршөөлийг

хүсэмжлэн, гэтэлгэлийн агуу төлөвлөгөөнд талархан, нулимс унаган залбирдаг уу?<sup>25</sup>

Авралыг дуулгавартай байдлаар биш, харин Бурханы хүүгийн цусаар худалдан авдаг юм.<sup>26</sup> Бид сайн үйлээр авралыг солилцож болно гэж боддог нь нисэх онгоцны тийз худалдаж авчихаад, онгоцыг өөрийнх хэмээн андууран бодохтой адил. Эсвэл байрныхаа түрээсийн төлбөрийг хийнгүүт, дэлхий ертөнцийг бүхэлд нь өмчлөх эрхийн гэрчилгээтэй болсон мэт санахтай адил юм.

### **Тэгвэл яагаад дуулгавартай байх ёстой вэ?**

Хэрвээ Бурханы ач ивээл нь бэлэг юм бол Бурханы зарлигуудад дуулгавартай байх нь яагаад тийм чухал гэж? Тийм юм бол Бурханы зарлиг тушаалууд эсвэл наманчлал гэгч зүйлтэй яагаад зууралдах ёстой юм бэ? Яагаад зүгээр л гэм нүгэлтэй гэдгээ хүлээн зөвшөөрч, Бурханаар аврагдаж болохгүй гэж?

Эсвэл Паулын “Нигүүлсэл нь ихсэхийн тулд бид нүгэл дотор байсаар байх уу?” гэсэн асуултыг тавих уу? Паул үүнд “Бүү ийм байх болтугай!”<sup>27</sup> хэмээн маш энгийн, тодорхой хариултыг өгсөн байдаг.

Ах, эгч нар аа, бид Бурханд хайртай учраас Түүний тушаалуудыг дагадаг!

Бурханы ач ивээлийн бэлгийг зүрх сэтгэл, оюун ухаанаараа ойлгохыг хичээх тусам Тэнгэрлэг Эцэгээ илүү даруу мөн талархалтай хайрлан хүндэлж, Түүнд дуулгавартай байх хүсэл төрдөг. Шавийн замаар алхах нь биднийг цэвэршүүлэн, хүчирхэгжүүлж, Түүнтэй илүү адил болоход туслахаас гадна Түүний оршихуйд буцаж очих зам руу удирдан хөтөлдөг. Их Эзэний [бидний Бурханы] Сүнс “хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгох, харин үргэлж сайныг хийх болгон, бидний зүрх сэтгэлд хүчирхэг өөрчлөлтийг . . .”<sup>28</sup> авчирдаг.

Тиймээс, Бурханы зарлигуудад дуулгавартай байх нь бид Түүний

нинжин сэтгэлийн төлөө цаглашгүй хайр, талархлаа илэрхийлж буй жам ёсны үр дагавар юм. Бодит хайр болон талархлын энэ илрэл нь бидний үйл хэргийг Бурханы ач ивээлтэй тун гайхалтай нэгтгэн холбож өгдөг. Ариун журам үргэлж бидний бодол санаанд байж, бидний итгэл Бурханы оршихуйд хүчирхэгжих болно.<sup>29</sup>

Хүндэт ах, эгч нар аа, сайн мэдээг итгэлтэй дагах нь дарамт биш. Энэ нь мөнх оршихуйн алдар сууг өвлөн авах бэлтгэл ажил буюу баяр баяслаар дүүрэн дадлага төдий зүйл билээ. Бидний сүнс сүнсэлэг зүйлст илүү их татагдахын хэрээр бид Тэнгэрлэг Эцэгээ дуулгавартай дагахыг эрэлхийлэх болно. Мөн бид урьд өмнө төсөөлж ч байгаагүй зүйлсээ ойлгож эхэлнэ. Бид Эцэгийнхээ хүслийг биелүүлэх тусам гэгээрэх бөгөөд ойлгох чадвар бидэнд өгөгдөнө.<sup>30</sup>

Ач ивээл нь Бурханы бэлэг бөгөөд Түүний зарлиг бүрд дуулгавартай байх хүсэлтэй байх нь Тэнгэрлэг Эцэгээсээ энэхүү ариун нандин бэлгийг хүлээн авахаар мөнх бус гараа сунгаж буй хэрэг юм.

### **Чадах бүхнээ хийх ёстой**

Бошиглогч Нифай “Бид Христэд итгэж, мөн Бурханд нийцсэн байхыг хүүхдүүддээ мөн түүнчлэн ах дүүстээ ятгахын тулд . . . хичээнгүйлэн хөдөлмөрлөв; учир нь *бид ач ивээлээр л аврагдана гэдгийг мэднэ, бидний хийж чадах бүхний дараа буюу*”<sup>31</sup> хэмээн тунхагласнаараа Бурханы ач ивээлийн талаарх бидний мэдлэгт чухал хувь нэмэр оруулсан билээ.

Гэхдээ “хийж чадах бүхний дараа” гэдэг үг хэллэгийг бид зарим үед буруу ойлгодог юм болов уу гэсэн бодол надад төрдөг. “Дараа” гэдэг нь “учраас” гэсэн үгтэй адил биш болохыг ойлгох хэрэгтэй.

Бид чадах бүх зүйлийнхээ “учраас” аврагдахгүй билээ. Бид бүгд чадах *бүх зүйлээ* хийсэн үү? Бурхан бидний амьдралд ач ивээлээ хайрлахаас өмнө бидний

зүгээс бүх хичээл зүтгэлээ гаргахыг хүлээдэг үү?

Олон хүн хийх ёстой зүйлээ бүрэн хийдэггүй учраас шантарч, сэтгэлээр унадаг. Тэд “сүнс хүсэж байна, харин махбод сул дорой юм”<sup>32</sup> гэдгийг хувийнхаа туршлагаас мэднэ. Тэд Нифайн “Бодгаль минь миний аддсын учир гашуудах ажгуу”<sup>33</sup> хэмээн тунхагласантай дуу хоолойгоо нэгтгэдэг.

Нифай Аврагчийн ач ивээл бидэнд гэм нүглийг даван туулах *боломж, чадварыг* олгодог гэдгийг мэдэж байсан нь гарцаагүй.<sup>34</sup> Тийм ч учраас Нифай өөрийн үр хүүхэд, ах дүү нарт “Христэд итгэж, мөн Бурханд нийцсэн байхыг”<sup>35</sup> ойлгуулахын тулд хичээнгүйлэн хөдөлмөрлөсөн юм.

Эцэст нь хэлэхэд, *энэ бол* бидний хийж чадах зүйл! Түүнчлэн *энэ бол* бидний мөнх бус байдалдаа хийж гүйцэтгэх ёстой үүрэг даалгавар мөн!

### **Ач ивээлээс хүн бүр хүртэх боломжтой**

Би анхны Христийн амилсны баярын ням гараг хүртэл Аврагчийн бидний төлөө хийсэн зүйлсийн талаар бодохдоо Хамгийн Агуу Дээд Бурхан болон Түүний Хүү Есүс Христийг чанга дуугаар магтан дуулахыг хүсдэг.

Тэнгэрийн үүд хаалга нээгдлээ!

Тэнгэрийн цонх нээгдлээ!

Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй хүмүүс Бурханы ач ивээлээс өнөөдөр төдийгүй, үеийн үед хүртэх боломжтой.<sup>36</sup> Есүс Христ бидний мөнх бус оюун ухаанаараа төсөөлөхийн аргагүй өндөрлөгт хүрэх замыг бэлдсэн.<sup>37</sup>

Бид Аврагчийн цагаатгагч золиослолын мөнхийн ач холбогдлыг өөр харц, өөр зүрх сэтгэлээр харах болтугай хэмээн би залбирч байна. Бид Бурханыг хайрлаж байгаагаа болон Түүний цаглашгүй ач ивээлийн бэлгэнд талархаж байгаагаа зарлигуудыг нь дагаж, “шинэ амийн дотор”<sup>38</sup> баяр баяслаар дүүрэн явснаараа харуулах болтугай хэмээн би залбирч байна. Бидний Эзэн мөн

Гэтэлгэгч, Есүс Христийн ариун нэрээр, амен.

#### ЭШЛЭЛҮҮД

1. 1 Коринт 15:55; Мозая 16:8-ыг үзнэ үү.
2. 1 Петр 1:3; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
3. 1 Тесалоник 4:18; мөн 13–17-г үзнэ үү.
4. Иаков 4:12.
5. 2 Нифай 25:26.
6. Алма 34:10, 15.
7. Ефес 3:18–19.
8. Сургаал ба Гэрээ 93:28.
9. Үнэнээр бид “бяцхан хүүхдүүд бөлгөө, мөн хичнээн агуу адислалуудыг Эцэг гартаа байлгаж мөн [бидний] төлөө бэлтгэснийг та нар хараахан ойлгоогүй байгаа билээ” (Сургаал ба Гэрээ 78:17).

10. Ром 3:23.
11. 1 Нифай 15:34; мөн 1 Нифай 10:21; Мосе 6:57.
12. Мозая 2:21.
13. Алма 42:15.
14. Алма 34:15.
15. Исаиа 1:18.
16. 1 Тимот 2:6.
17. 2 Петр 1:11-ийг үзнэ үү.
18. Сургаал ба Гэрээ 76:56.
19. Сургаал ба Гэрээ 76:59-ийг үзнэ үү.
20. Сургаал ба Гэрээ 84:38-ыг үзнэ үү.
21. Мозая 27:25.
22. Моронай 10:32.
23. Ифер 12:27-г үзнэ үү.
24. Лук 7:36–50; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
25. Есүсийн фарисай хүний тухай болон

- татвар хураагчийн талаарх сургаалт үлгэр нь энэхүү санааг тодорхой харуулсан байдаг (Лук 18:9–14-ийг үзнэ үү).
26. Үйлс 20:28.
  27. Ром 6:1–2.
  28. Мозая 5:2.
  29. Сургаал ба Гэрээ 121:45-ыг үзнэ үү.
  30. Иохан 7:17-г үзнэ үү.
  31. 2 Нифай 25:2 3; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
  32. Матай 26:41; мөн Ром 7:19-ийг үзнэ үү.
  33. 2 Нифай 4:17.
  34. 2 Нифай 4:19–35; Алма 34:31-ийг үзнэ үү.
  35. 2 Нифай 25:23.
  36. 3 Нифай 9:19–20-ийг үзнэ үү.
  37. 1 Коринт 2:9-ийг үзнэ үү.
  38. Ром 6:4.